




ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

2020.05.25

Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст сарын эхэнд бүртгэлтэй ажил идэвхтэй хайгч 362 иргэн байгаагаас тайлант сард 294 иргэн шинээр бүртгэгдэж, бүртгэлээс 181 иргэн хасагдаж, тайлант сарын эцэст 475 иргэн бүртгэлтэй болсон байна. Ажилд зуучлагдсан 208 иргэн байна.

ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст шинээр бүртгүүлсэн болон ажилд орсон иргэд, сүүлийн 5 жилийн 05-р сарын байдлаар харуулахад.

Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст шинээр бүртгүүлсэн болон Ажилд орсон иргэд, жил бүрийн 05-р сарын байдлаар /өссөн дүнгээр/




Тухайн сарын ажил зуучлал: Ажилд зуучлагдсан 68 иргэнээс 27 эмэгтэй, Үүнээс: менежер 1, мэргэжилтэн 11, техникийн болон туслах 3, Контор, үйлчилгээний ажилтан 3, Худалдаа, үйлчилгээний ажилтан 1, ХАА, ой, ажилтан 17, үйлдвэрлэл, барилга, гар урлал, бусад ажил үйлчилгээний ажилтан 0, оператор 1, энгийн ажил 31, зэвсэгт хүчин 0 зуучлагдсан байна. **Өссөн дүнгээр нийт 208 ажил хайгч иргэн /байнгын-52, түр-156/ ажлын байранд зуучлагдсан байна.**

Шинэ ажлын байр: 5 сарын шинээр 16 ажлын байр бүртгэгдсэн байна. Үүнээс: 10 эмэгтэй. менежер 4, мэргэжилтэн 9, техник туслах 0, Контор, үйлчилгээний ажилтан 0, Худалдаа, үйлчилгээний ажилтан 0, ХАА, ойн ажилтан 0, үйлдвэрлэл, барилга, гар урлал, бусад ажил үйлчилгээний ажилтан 0, суурин төхөөрөмж, оператор 0, энгийн ажил 3, зэвсэгт хүчин 0 тус тус бүртгэгдсэн байна. Улирлын чанартай ажлын байр 0, түр ажлын шинэ ажлын байр 1 бүртгэгдсэн.


Энэ сард Хөдөлмөрийн хэлтсийн мэдээллийн санд ажил идэвхтэй хайж байгаа 475 иргэн бүртгэлтэй байгаа ба 231 нь эмэгтэйчүүд байна. Мэдээллийн санд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа иргэдийг боловсролын түвшингээр авч үзвэл: магистр 2, дипломын болон дээд боловсролтой 63, тусгай мэргэжлийн дунд 15, техникийн болон мэргэжлийн анхан шатны 45, Бүрэн дунд 211, суурь 94, бага боловсролтой 36, боловсролгүй 9 иргэн бүртгэтэй байна.

Бүртгэлтэй ажил хайгч иргэдийг боловсролын түвшингээр харвал



2020 оны 05 сарын байдлаар аймгийн хэмжээнд бүртгэлтэй 475 ажил хайгч иргэдийн 48,6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Нийт ажил хайгч иргэдийн 16 нь буюу 3,4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Бүртгэлтэй ажил хайгч иргэдийг насны бүлгээр харвал



**ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН
АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГА**

Орон нутгаас зарлагдсан тендерт оролцогч ААНБ-тай ажиллах хүчин нийлүүлэх хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Үүнд: 2020 оны 5 сарын байдлаар нийт 33 ААНБ-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Тендерт шалгарсан ААНБ-ууд нийт 80 иргэдийг түр ажлын байраар ханган ажиллаж байна.